

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ 9 ДҮГЭЭР ФОРУМЫН ТАЙЛАН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

2018 он

АГУУЛГА

- Товч танилцуулга
- Үйл ажиллагааны чиглэл
- Хийсэн ажлууд
- Форумын тайлан, санал, зөвлөмж
- Цаашид хийгдэх ажлууд

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол улсад байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий
цэвэр, нөхөн сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг
дэлгэрүүлэх, хурдацтай өсөлтийг дэмжих зорилготой гишүүдэд
үйлчлэх ТББ юм.




Удирдах зөвлөлийн дарга
Р.Бадамдамдин




Ерөнхийлөгч
Ж.Осгонбаатар



Ерөнхий нарийн бичгийн дарга
Э.Мягмардорж



**Хөтөлбөрийн
мэргэжилтэн**
Б.Болортуяа



Судлаач, аналит
Н.Аюушцэрэн



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛҮҮД

Бодлогын
орчин
сайжруулах

Төсөл
хөтөлбөр
хэрэгжүүлэх

Уулзалт,
хэлэлцүүлэг
зохион
байгуулах

Боловсон
хүчний чадавхи
бэхжүүлэх

Гишүүдэд
үйлчлэх,
мэдээллэх,
сурталчлах

ХИЙСЭН АЖЛУУД

- 2018.02.28 – Сэргээгдэх эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгч компаниуд уулзалт товлон “Нэгдсэн сүлжээний дүрэм”, “СЭХ-ний хууль”-ийн шинэчлэлийн талаар санал бодлоо хуваалцав.



- 2018.03.30 – “Нарны энергийг байгууллагын цахилгаан хэрэглээ болон ус шавхуургын зорилгоор ашиглаж буй туршлага” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.



ЦААШИД ХИЙГДЭХ АЖЛУУД

- Сэргээгдэх эрчим хүчний үндэсний Аравдугаар форум
 - Эрдэм шинжилгээний бага хурал
 - Мэргэжлийн хурал, хэлэлцүүлэг
- Улирал бүр мэргэжлийн хурал, хэлэлцүүлэг

- ШТС-ын цахилгаан хэрэглээг нарны эрчим хүчээр хангах;
- Уул уурхайн станцуудын хэрэглээг СЭХ-ээр хангах;
- Хөдөө орон нутагт нарны эрчим хүчээр ажиллах гүний усны шавхуурга суурилуулах;
- Хог хаягдал боловсруулах замаар эрчим хүч гарган авах төсөл;
- Хилийн боомтын цахилгааныг “СЭХ-дизель түлш” хосолсон системээр шийдэх;

2018.05.23

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ



МЭРГЭЖЛИЙН СЕМИНАР



“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний 9-р форум”

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ IX ҮНДЭСНИЙ ФОРУМ

The Corporate Hotel and Convention Center
2018.05.24

Ерөнхий зохион байгуулагч



Хамтран зохион байгуулагч



ИВЭЭН ТЭТГЭГЧИД

ТераВатт



ГигаВатт



МегаВатт



килоВатт



Дэмжигч байгууллага




Хэвлэл мэдээллийн ивээн тэтгэгч




Сэргээгдэх эрчим хүчний үндэсний 9-р форумд дотоод, гадаадын 600 гаруй зочид оролцов

Оролцогчид



Хүйсийн харьцаа



САЛХИТ САЛХИН ЦАХИЛГААН СТАНЦЫН АЯЛАЛ

3 дахь жилдээ
уламжлал болгон
зохион байгуулав.



**Тус аялалыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлдэг Клин Энержи ХХК-д
талархал илэрхийлэе**

Форумаас гарсан үр дүн, санал, зөвлөмж



- 2019 оны төгсгөл гэхэд нар, салхины эрчим хүчний суурилагдах хүчин чадал 300 МВт-д хүрч, системийн нийт суурилагдсан чадлын 22-25 хувьд хүрэх төлөвтэй байна.
- Монгол улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнд сэргээгдэх эрчим хүчийг 30 хувиас илүү шингээх техникийн боломж хязгаарлагдмал байна.

Ц.Даваасүрэн:

Бид дэлхийн чиг хандлагыг дагах, мөн утааг бууруулахад сэргээгдэх эрчим хүчийг ашиглах үүднээс ашиглаж болох гарцуудыг хайж байна.

1. Нөөцлүүрийн систем байгуулах боломжийг судалж байгаа. Урьдчилсан байдлаар 100 МВт-ын батарейн систем судалж байна. Мөн усан цахилгаан станцуудыг байгуулах нь чухал.
2. Метаны хийг ашиглах чиглэлээр судалгаа хийж байна. Ойролцоогоор 200 МВт –ыг байгуулах боломжтой гэж үзэж байна.
3. Монгол улсын алсын амбиц бол Азийн супер сүлжээнд нэгдэх юм. Уг сүлжээнд нэгдэн ажиллахад Монголын өмнөд говийн нарны болон салхины эрчим хүчний арвин нөөц нь чухал үүрэг гүйцэтгэх юм.

ХУРАЛДААН 1: ДЭЛХИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ЧИГ ХАНДЛАГА БА МОНГОЛ УЛС



Mr. JARGALSAIKHAN
Dambadarjaa



Mr. BAVUUDORJ
Ovgor



Mr. BASSAIKHAN
Dash



Mr. JON
McDaniel



Ms. LIMING
Qiao




Mr. BATJARGAL
Zamba

**“Дэлхийн эрчим хүчний бодлого:
Чиг хандлага, бодлогын онцлох
байдал”**



Кэрол Литвин, (GGGI)-ын Хөрөнгө оруулалт,
бодлогын шийдлийн газрын Дэд захирал,
Эрчим хүчний хөтөлбөрийн Тэргүүн

**“Эрчим хүчний салбарын
зохицуулалт, сэргээгдэх эрчим хүчийг
цаашид хөгжүүлэх чиглэл”**



Эрчим хүчний зохицуулах хорооны Зах зээлийн
судалгаа, хамтын ажиллагааны хэлтсийн Дарга
Л.Жамбаа

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ НЬ ДАРААХ СЭДВҮҮДЭД ЧИГЛЭВ:

- Сэрээгдэх эрчим хүчийг дэмжихэд тулгамдаж буй эрх зүйн орчин;
- Эрчим хүчний салбар дахь төлөвлөлтийн алдаанаас үүдсэн сэргээгдэх эрчим хүчний хөгжүүлэлтийн хүндрэл;
- Эрчим хүчний салбар дахь хэт улс төрөөс хамааралтай үнийн зохицуулалт ба дэмжих тариф;
- Эгийн голын усан цахилгаан станц ба Монгол улсын цэвэр усны нөөцийн асуудал;

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Эрчим хүчний салбарт улс төрийн нөлөө хэт их буйгаас хамааран хэрэглээ, хангамжийн төлөвлөлтийг хийхэд хүндрэлтэй байдал үүсч байна ;
- Байгаль орчны яам болон Эрчим хүчний яамны сэргээгдэх эрчим хүчний салбар дахь бодлого нь зөрүүтэй байна ;
- Уламжлалт эх үүсвэрүүд дээр өгч буй хөндлөн татаасыг хязгаарлах замаар дэмжих тарифыг нэмэгдүүлэхгүй байх боломжтой ;
- Сэргээгдэх эрчим хүчнээс борлуулах тарифыг ам.доллароор тогтоосон нь зөв шийдэл боловч гагцхүү төгрөгийн ханш унасаар байгаа нь үнэтэй байх нөхцлийн нэг нь болж байна ;


- Цахилгаан эрчим хүчний үнийн чөлөөлснөөр амьжиргааны түвшин доогуур хэрэглэгчдэд эдийн засгийн дарамт үүсэх боловч үүнийг тусгайлсан дэмжлэг үзүүлэх бодлогоор шийдвэрлэх боломжтой ;
- Монгол улсын нутаг дэвсгэрт цөлжилт маш ихээр бий болж байгаа нь дан ганц улс орны дотоод асуудал биш, дэлхий нийтийн асуудал юм. Иймд гадагшаа урсгалтай гол мөрнүүдээ ашиглан цэвэр усны нөөцийн асуудлаа хараат бусаар шийдвэрлэж, цөлжилттэй тэмцэх нь зүйтэй ;
- Цахилгаан эрчим хүчний үнэ, өртгийг бодитойгоор тооцож, хөрөнгө оруулалтын зардлыг суулгаж өгөх хэрэгтэй. Ингэж чадвал эрчим хүчний салбар дахь эдийн засгийн үндсэн асуудлууд шийдэгдэх болно ;
- Төрийн өмчлөлийн уламжлал эх үүсвэрүүд хөрөнгө оруулалтын зардлыг суулгаж өгснөөр, ашиглалтаас гарсан нөхцөлд түүнийг орлох дараагийн эх үүсвэрийн зардлын тодорхой хэсгийг бүрдүүлсэн байх нь зүйтэй ;

ХУРАЛДААН 2: “ТӨВЛӨРСӨН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМД ХОЛБОГДООГҮЙ ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН МИКРО-СҮЛЖЭЭНИЙ ШИЙДЭЛ”



С.НАРАНТӨГӨЛДӨР

Энжи группын Монгол дахь
төлөөлөгчийн газрын Захирал



Г.ТУУЛ

Хас банкны Эко банкны захирал



“ТӨВЛӨРСӨН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМД ХОЛБОГДООГҮЙ ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН МИКРО-СҮЛЖЭЭНИЙ ШИЙДЭЛ”

Монгол улсын ТБНС-тэй зэрэгцээ ажиллах микро
сүлжээг байгуулснаар дараах үр ашигтай:

- Давтамжийг тохируулах;
- Хүчдэлийн уналтыг бууруулах;
- Горим тохируулгыг удирдах ;
- Шаардлагатай нөхцөлд бүс нутгийг цахилгаан хангамжийн найдвартай байдлыг хангах ;

“МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖИХ СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСЛҮҮДИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОМЖ”

Сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд санхүүжилт олгоход дараах шалгуурууд тавигддаг:

- “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол улсын хувь нэмэр” гэсэн бодлогын бичиг баримтад нийцсэн байх ;
- Монгол улсын эрчим хүчний бодлогод 2023 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэх зорилгод нийцүүлэх ;
- Төслийн нийт өртгийн 50 хүртэлх хувийг санхүүжүүлэх боломжтой ;
- Тухай төслийн нийт санхүүжилтийн 20 хувийг төсөл хэрэгжүүлэгч гаргах чадвартай байх ;
- Хүлэмжийн хийн бууралтаа өөр улс оронд тооцуулсан төсөл санхүүжилт авах боломжгүй. Өөрөөр хэлбэл, НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан нь Карбоны санхүүжилттэй хамт хэрэгждэггүй ;

Мануэл Рейбанд

“Вестас” Ази-Номхон далайн
борлуулалт хариуцсан Ахлах
Зөвлөх



Б.АВИРМЭД

Шугам ХХК-ны Захирал



“СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИНД СУУРИЛСАН ТӨВЛӨРСӨН БУС СИСТЕМ БАЙГУУЛАХ БОЛОМЖ БА ШИЙДЭЛ”

Эрчим хүчний хосолсон системийн ажиллагааг туршихын тулд Австрали улсад 3.3 МВт салхины үүсгүүр, 1.5 МВт нарны үүсгүүр, 2 МВт.ц нөөцлүүрийн системийг суурилуулсан.

Монгол улсад бие даасан эрчим хүчний систем, шийдлийг яагаад байгуулах шаардлагатай вэ?

- Монгол улсад сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх нэгдсэн сүлжээн дэх зах зээл нь хязгаарлагдмал;
- Шинэ хэрэглэгч нэгдсэн сүлжээнд холбогдоход маш хүндрэлтэй, хүнд сурталтай;
- Эрчим хүчний найдвартай, аюулгүй ажиллагаа, чанарын асуудал нь хурцадмал байдалтай болсон;

ХУРАЛДААН 3: НЭГДСЭН СҮЛЖЭЭН ДЭХ СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН



Mr. OSGONBAATAR
Jambaljamts



Mr. Dr. OLIVER
Shnorr



Mr. JIGJID
Rentsendoo



Mr. ORCHLON
Enkhtsetseg



Mr. GANZORIGT
Luvsanjamba



Mr. SERGELEN
Tumurbagana

Майк Гилмор

“Вестас” группын Зүүн хойд
Азийн бүс хариуцсан төслийн
удирдагч



“ЦЭЦИЙ САЛХИН ЦАХИЛГААН СТАНЦ”

9 сарын хугацаанд 965000 хүн цаг осол аваарьгүй
ажиллаж, ашиглалтанд оруулав

Түүхэндээ анх удаа 1 өдрийн дотор 2 ширхэг салхин
турбиныг босгосон бол турбины суурийн ажлуудыг
100 хувь Монгол ажилчид гүйцэтгэсэн.

Э.ОРЧЛОН

Ньюком группын ТУЗ-ын
Гишүүн бөгөөд Клин Энержи
Ази ХХК-ны Гүйцэтгэх захирал



“МОНГОЛ УЛСЫН СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖҮҮЛЭЛТ”

Цэций салхин цахилгаан станцын хөрөнгө оруулалтын 70 хувийг
зээлээр шийдвэрлэсэн. Энэхүү зээлийн хүү нь доор
эрсэдлүүдээс хамаарч хэлбэлзэж байгаа:

- LIBOR (Банк хооронд зээлийн хүү)
- Төслийн эрсдэл (Төслөө хугацаанд хэрэгжүүлж чадах уу г.м)
- Улсын эрсдэл (Тухай улс орны улс төр, эдийн засгийн чадавхиас хамаарч, гэрээний үүргээ биелүүлж буйгаас хамаарч байдаг)

Б.БАТЛХАГВА

Монхорус Интернэйшнл ХХК-ны
Дэд бүтэц хариуцсан Захирал




“СҮЛЖЭЭНИЙ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ БА НӨӨЦЛҮҮРИЙН СИСТЕМ”

Эрчим хүчний тогтвортой ажиллагааг хангахад ФАКТС (FACTS – Flexible AC Transmission System: Уян хатан хувьсан гүйдлийн дамжуулах сүлжээ) шийдлийг ашиглах боломжтой.

1. Цуваа холбоотой компенсцлах төхөөрөмж: Удирдлагатай, удирдлагагүй гэсэн 2 төрөлтэй. 1950 оноос хойш ашиглагдаж байгаа.
2. Шунтийн компенсцлах төхөөрөмж: SVC, STATCOM гэсэн 2 төрөлтэй;
3. SVC Light with Energy Storage DynaPeaQ шийдэл буюу Өөр дээрээ эрчим хүчний нөөцлүүртэй горим тохируулгын шийдлийг 2010 оноос хойш ашиглаж байгаа.

ЭНДИ ЛИЙ

МЭЙК (MAKE) Консалтинг,
Ази-Номхон далайн бүс
хариуцсан Ахлах Зөвлөх



“ДЭЛХИЙН ДАХИН ДАХЬ САЛХИНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ БОДЛОГЫН ТОЙМ”

БНХАУ-ын Засгийн газар, Үндэсний Эрчим Хүчний Хорооны мэдээлснээр “2022 он гэхэд салхины эрчим хүчний үйлдвэрлэл нь нүүрсний эрчим хүчний үйлдвэрлэлтэй тэмцэнэ” гэжээ.

Үүний тулд 2019 оноос эхлэн одоо хэрэгжиж буй дэмжих тарифаас өрсөлдөөнт зах зээл рүү шилжинэ гэдгээ мэдэгдээд байна.

Б.БААТАР

Диспетчерийн үндэсний төвийн
Ахлах диспетчер



“НЭГДСЭН СҮЛЖЭЭНИЙ ДҮРМИЙН ӨӨРЧЛӨЛТ БА ГАРАХ ҮР ДҮН”

Одоогийн байдлаар 3 төрлийн гэрээний төрөл мөрдөгдөж байна:

- Уламжлал буюу ДЦС-уудад зориулагдсан гэрээ;
- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдэд зориулагдсан гэрээ;
- Бие даасан эх үүсвэрийн буюу том чадлын нүүрсний цахилгаан станцуудтай байгуулах гэрээ (Жишээ нь Багануурын ЦС);

“Нэгдсэн сүлжээний дүрэм”-д нэмэлтээр 3 бүлэг, 33 зүйл, 122 заалт (41 заалтын найруулга өөрчилсөн) -г оруулсан. Дүрмийн эцсийн төсөлд дараах өөрчлөлтүүд тусгагдсан:

- Нэр томъёонууд шинэчлэгдсэн;
- Эрчим хүчний чанарын холбоотой 1 заалт нэмэлтээр, 2 заалт шинэчлэн найруулагдсан;
- Эрчим хүчний балансын тооцоотой холбоотой 2 заалтын найруулга шинэчилсэн;
- Шинэ объект хэрэглэгчийг холбохтой холбоотой заалтууд шинэчлэгдсэн;
- Тоолуурын системийн бүлэг нэмэгдсэн;
- Релей хамгаалалтын тусдаа бүлэг нэмэгдсэн;
- Сэргээгдэх эрчим хүчний 8 зүйл, 27 заалт бүхий шинэ бүлгийг тусад нь нэмэлтээр орсон.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ДҮГНЭХ НЬ:

- Нэгдсэн сүлжээний дүрэм нь технологийн зохицуулалтыг хангах зориулалттай тул арилжааны зохицуулалтыг тусгайлан авч үзэх. Мөн өнөөгийн хүндрэлтэй байдлыг шийдвэрлэхэд бус ирээдүйн хөгжил дэвшлийг харж боловсруулах хэрэгтэй;
- Диспетчерийн зохицуулалттай сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн “нэмэх”, “хасах” зөрчлийг тооцох дүрэм, журмыг боловсронгуй болгох;
- Цахилгаан худалдах, худалдан авах гэрээг байгуулахдаа талуудын эрх хуваарилах болон арилжааны асуудлуудад анхаарал хандуулах хэрэгтэй;
- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс нэгдсэн сүлжээнд үзүүлж буй нөлөөллийг ФАКТС (FACTS – Flexible AC Transmission System: Уян хатан хувьсан гүйдлийн дамжуулах сүлжээ) шийдлийг ашиглан шийдвэрлэж буй туршлагыг судлах, нэвтрүүлэх. Энэхүү шийдлийг нэвтрүүлснээр шугамын дамжуулах чадварыг нэмэгдүүлэх, сүлжээний чанарын стандарт шаардлага хангуулах давуу талуудыг олгоно;

- Цахилгаан худалдах, худалдан авах гэрээний заалтуудын үүргийг биелүүлэх;
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгагдаад буй өрсөлдөөнт (Auction) зах зээл нь Монгол улсын жижиг зах зээлд тохиромжгүй бөгөөд олон улсад их чадлын төслүүдэд ашигладаг гэдгийг анхаарах;
- Монгол улсад байгуулагдаж буй салхины эрчим хүчний төслүүдийн нийт хөрөнгө оруулалтын 1/3 хувийг тоног төхөөрөмжийг зардал эзэлдэг тул дэлхий дахин дахь үнийн бууралт нь төслийн тарифыг бууруулахад шууд нөлөө үзүүлэхгүй байгааг анхаарах;
- Сэргээгдэх эрчим хүчний хуультай холбогдох дүрэм, журмыг боловсруулах;

- Сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг дийлэнх хөрөнгө оруулалт нь зээлийн хүүгээр шийдвэрлэгддэг ба зээлийн хүү нь тухай улс орны эдийн засгийн чадавхи, эрх зүйн орчны тогтвортой байдлаас хамаарч хэлбэлзэж байдгийг анхаарах;
- Хуулинд тусгагдсан төрийн байгууллагын үүргийг чандлан биелүүлэх;
- Бизнесийн төслүүдтэй холбоотой дүрэм, журам, эрх зүйн бичиг баримтуудыг аль болох урт хугацаанд тогтвортой мөрдөх;
- Дотоод дахь цахилгаан хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах бодлого баримтлах;

ХУРАЛДААН 4:

ХОТ, СУУРИН ГАЗРЫН ХЭРЭГЛЭЭНД СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭВТРҮҮЛЭХ ЗАМААР АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ БОЛОМЖ



Ms. ARIUNBILEG
Oyunbilegt



Mr. BOLOR-ERDENE
Basbayar



Mr. ROMAIN
Brillie



Mr. PUREVSUREN
Dorj



Mr. BATLKHAGVA
Batsuren

Ц.Цолмонбаатар

Степпе Солар ХХК-ны Гүйцэтгэх
Захирал



“ӨРХИЙН БОЛОН БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЛЭЭНД ГАЗРЫН ГҮНИЙ ДУЛААНЫГ АШИГЛАЖ БУЙ ТУРШЛАГА”

Улаанбаатар хотын хэмжээнд газрын гүний дулааныг ашиглахад Өрөмдлөгийн гүн нь ойролцоогоор 120 метр байх үед газрын гүнээс - 1°C - +3°C –н нам температуртай 3.8 кВт.ц дулаан гарган авах боломжтой ба 1.9 кВт.ц цахилгаан ашиглан +65°C хүртэл өсгөж, нийт 5.7 кВт.ц дулаан үйлдвэрлэн 70 м² талбайг бүрэн хангах боломжтой.

газрын гүний дулааны ашиглахад хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах, хэрэглээг нэмэгдүүлэхэд дараах арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй:

1. Олон хэрэглэгчийн дунд том чадлын систем суурилуулж, нэгдсэн байдлаар халаах ;
2. Томоохон нуурыг эрэг дээр байрлах сум, суурин газрууд (жишээ нь Хөвсгөл аймгийн Хатгал тосгон нь дулаан хангамжиндаа маш их мод ашигладаг)-дад УС-УС төрлийн дулааны насосыг их чадлаар ашиглах боломжтой ;
3. Сэргээгдэх эрчим хүчнээс үйлдвэрлэж буй дулаанд тарифын дэмжлэг огт байхгүй, зохицуулалтгүй байна



Шинэ генератор 20 сая төгрөг
Жилийн урсгал зардал 15 сая төг

63.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 7.8 кВт чадалтай нарны эх үүсвэр суурилуулсан.

ШТС-аа нарны эрчим хүчээр хангаснаар дараах давуу талууд бий болох боломжтой:

- Сар бүрийн урсгал зардал 80 хувь буурна;
- Түлшний хэрэглээгүй болно ;
- Бүх төрлийн хэрэглээгээ нараар шийдэж, эко орчин бий болно ;
- Ажлын байрны орчин, эрүүл ахуйн хувьд сайжирна ;
- ШТС-ын байршил өөрчлөх шаардлага гарсан үед шилжүүлэн суурилуулахад хялбар ;
- Эко ШТС-ыг бий болгосноор дотоод зардал буурч, шатахууны үнэ 1 л тутамд 20 төгрөгөөр буурах боломжтой (Сопоко ХХК-ний хэрэглэгчийн судалгаан дээр хийсэн тооцоолол) ;

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ДҮГНЭХ НЬ

- Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс сүлжээнд нийлүүлсэн цахилгааныг худалдан авах тариф нь хөрөнгө оруулалтаа богино хугацаанд нөхөх чадамжтай байхаар тогтоох;
- Дизель генератороос агаарын бохирдлыг үүсгэж буй нөлөөллийг бууруулахын тулд хот суурин газар дахь ШТС-уудын цахилгаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр шийдвэрлэх;
- Уламжлалт эрчим хүчний эх үүсгүүр олгож буй татаасыг сэргээгдэх эрчим хүчинд олгох замаар хот суурин газар сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэлгэрүүлэх;
- Агаарын бохирдлыг бууруулах сангийн хөрөнгөөр өрхийн болон албан байгууллагын хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах дэмжлэг үзүүлэх зорилгоор татаас олгох;

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.

ХОЛБОО БАРИХ

secretary@mria.mn

[\(+976\) 8808 4850, 7747 4850](tel:+9768808485077474850)

www.MRIA.mn